



**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин Буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/							
ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо	24.142	26.000	Тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлэх ,Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хэрэгжүүлэн дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд: Завхан аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэд сурталчлах өдөрлөгт 16 иргэнд, Хуульчдын “Про боно” өдөрлөгт 20 иргэнд, Отгон суманд нээлттэй хаалганы өдөр зохион байгуулахад 24 иргэнд цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажилласан байна. Аймгийн хэмжээнд насанд хүрсэн нийт 49813 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2024 оны тайлант хугацаанд 24142 иргэнд буюу 48,4 хувьтай байсан бол 2025 оны тайлант хугацаанд өссөн дүнгээр 5330 иргэнд нийт 29472 иргэнд тоон гарын үсэг олгож. Цахим гарын үсэг олголт 59,1 хувьтай явагдаж байна. Мөн Улсын бүртгэлийн	100%

						киоск машинаас 760 иргэн тоон гарын үсэг авсан бүртгэлтэй байна.	
1.2.	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх /1.8/	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	-	1	Өгөгдлийн шинжилгээг хийхдээ бүртгэлүүдийн сүүлийн 3 жилийн тоог харьцуулж график гарган харьцуулалтын аргаар хийсэн болно. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Иргэний бүртгэлийн чиглэлээр 6142 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 2298, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 833 бүртгэлүүд тус тус хийсэн нь 0,5-0,9 дахин илүү бүртгэл хийсэн дүнтэй байна.	100%
1.3.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдалд хяналт тавих/1.9/	-	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь	100	100	Шилэн дансны тухай хуулийн дагуу эхний хагас жилийн байдлаар байршуулах ёстой мэдээллийг 100 хувь байршуулсан.	100%
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	171	171	Шилэн дансны нэгдсэн системд оруулах ёстой 68 мэдээлэл оруулахаас 68 мэдээллийг info.shilendans.gov.mn сайтанд хугацаанд үнэн зөв байршуулсан. 1-р улирлын тайланг хугацаанд нь илгээсэн.	100%
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1.	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх,сурталчилах	-	E-mongolia үзүүлсэн иргэдийн тоо	4869	4900	Улсын бүртгэлийн үйлчилгээг Баруун бүсийн үйлчилгээний Хурдан төв, АЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, ХХҮГазрын Гэрэгэ киоск машинуудаар дамжуулан иргэдэд үзүүлэхээс гадна хэлтсийн үйлчилгээний зааланд ДӨТ болон Гэрэгэ киоск ажилуулан үйлчилгээг үзүүлэн ажилласны үр дүнд 2660 иргэн үйлчилгээ авсан байна. Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим /киоск/ машинаар үзүүлэх үйлчилгээ, Улсын бүртгэлийн хууль тогтоомж, өдөр тутмын үйл ажиллагааг хэлтсийн фэйсбүүк болон пэйж хуудсаар тогтмол сурталчлан ажиллаж тайлант хугацаанд И-Монголоос гаргасан нийт 13 мэдээ мэдээлэл, 6 контентыг хэлтсийн цахим хуудаст байршуулж 265 удаагийн давтамжтайгаар олон нийтэд түгээн ажилласан байна.	50%
		-	E-business үзүүлсэн иргэдийн тоо Сурталчилсан тоо	762	800	E-business цахим системээр Хуулийн этгээдийн оноосон нэрийн 597 хүсэлтийг хүлээн авч 54 оноосон нэрийн баталгаажуулалтыг хийсэн.	70%

2.2	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид санал өгөх, сурталчлах	-	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилсан тоо	2	3	Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Завхан аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэд сурталчлах өдөрлөгт 16 иргэнд, Хуульчдын “Про боно” өдөрлөгт 20 иргэнд, Отгон, Шилүүстэй суманд нээлттэй хаалганы өдөр зохион байгуулахад 24 иргэнд, Завхан аймгийн Татварын хэлтсийн албан хаагчидад “Эд хөрөнгийн үнэлгээ” сэдвээр, Аймгийн бизнес эрхлэгчид “Улсын бүртгэлд хуулийн этгээдийг бүртгүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр сургалтыг 96 иргэнд хууль тогтоомжын талаар сурталчлан ажилласан. Улсын бүртгэлийн тухай багц хуулийн хэрэгжилттэй холбогдуулан фэйсбүүк пэйж хуудас болон цахим хуудсаар дамжуулан сурталчилж 2025 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд нийт 82 мэдээ мэдээлэл, үйл ажиллагаатай холбоотой 6 контентыг бэлтгэн байршуулж 500 гаруй удаагийн давтамжтайгаар олон нийтэд түгээн ажилласан	70%
		-	Боловсруулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд санал хүргүүлсэн тоо	-	3	Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын газар, хэлтсээс ирүүлсэн 3 удаагийн төсөлд санал хүргүүлсэн байна. Үүнд 1.УБЕГ-н ЭХЭБГ-н 2025.04.11 ны 5/5118 албан бичгийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд тусгах саналыг 2025.04.16ны 21/164 албан бичгээр 2.УБЕГ-н Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2025.04.17 ны 4/5440 албан бичгийн дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 2025.05.15 ны 21/238 албан бичгээр 3. УБЕГ -н БТДШГ -с 2025.06.06 ны 7/7662 албан бичгийн Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд холбогдох саналуудыг албажуулан хүргээд байна.	100%

2.3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх.	-	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	6	11	Баянтэс, , Цагаанхайрхан, Цагаанчулуут, Тосонцэнгэл, Сонгино Их-Уул, Тэлмэн, Тэс, Нөмрөг, Сантмаргаз сумдад 795-н эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлээд байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт Асгат, Ургамал суманд эрх нээлгэх хүсэлт холбогдох судалгааг хүргүүлсэн байна. Баянтэс, Сонгино, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн, Тэс, Нөмрөг, Сантмаргаз, Асгат сумдад 385-н хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.	50%
2.4	Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулах	-	Цахимжуулсан хувийн хэргийн тоо	15	20	Иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа тодорхойгүй төлөвтэй 824 иргэний хувийн хэргийг мэдээллийн санд шалгаж нийслэл болон бусад аймгийн хаягтай 521 иргэний ХААТР -11 маягт болон хувийн хэргийг харьяа аймаг нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн ба Завхан аймгийн хаягтай 327 иргэний хувийн хэргийг иргэний баримтын архивт баяжилт хийж цахимжуулсан байна.	100%
2.5	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх зөөврийн тоног төхөөрөмжийн программ хангамжийг сайжруулах, тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх		Зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо	1	2	Зөөврийн 4G тоног төхөөрөмж ашиглан өөрийн биеэр ирж үйлчилгээ авах боломжгүй Улиастай сумын 5 ,Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 04 дугаар сарын 01-ны өдөр 3 хүмүүжигчид , "ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР 2025" өдөрлөгт 20 иргэнд , зөөврийн тоног төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан. Мөн Отгон, Шилүүстэй сумдын ЗДТГазартай хамтран нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 5 дугаар сарын 12-14 нд Отгон, Шилүүстэй сумдад Зөөврийн 4G тоног төхөөрөмж ашиглан зохион байгуулсанаар Иргэний улсын бүртгэл-20, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 30 ,Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 5 үйлчилгээг, тус тус үзүүлэн ажиллаа. 2025-05-29 өдөр Завхан аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэд сурталчлах, энхийг	50%

						сахиулагчдын алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор аймгийн Төв талбайд уг арга хэмжээг хамтран зохион байгуулав. Тухайн арга хэмжээнд 16 иргэнд Зөөврийн төхөөрөмж ашиглан тоон гарын үсэг олголоо.	
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах, архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	Улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах зорилгоор иргэний улсын бүртгэлийн 92, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 98, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 59 бүртгэлд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавин ажиллаж, иргэний 1, эд хөрөнгийн 2, хуулийн этгээдийн 14 бүртгэлийн зөрчлийг арилган, 1 бүртгэлийг хүчингүй болгон, бүртгэлд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох 23 дүгнэлт гарган холбогдох газруудад хүргүүлсэн. Архивын 287 бүртгэлийн эх нотлох баримтын цахимжуулалт, 34 лавлагаа олголтонд хяналт шалгалт хийж 2 улсын бүртгэгчид албан шаардлага бичиж, хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхтэй бүртгэгч нар мэдэгдэл, зөвлөмж өгч ажиллав. Мөн Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон хугацаанд иргэний улсын бүртгэлд бүртгүүлээгүй 86 иргэнд холбогдох хуулийн дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж 1.720.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаж байна.	50%
3.2	Улсын бүртгэлийн хэлтсийн компьютер, түүний дагалдах техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн, сайжруулах		Техник, тоног төхөөрөмжийн шинэчилсэн тоо	4	4	Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасагт ADB төслийн хүрээнд Компьютер, скайнер тус бүр нэг нэгийг олгож үйлчилгээнд ашиглаж байна.	50%
3.3.	Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн	-	-Зөвлөмж,акт,албан шаардлагын тоо,биелэлтийн хувь	100	100	Аудитын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулалтаар ямар нэгэн	100%

	зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх		-Мэдээ мэдээллийг тухай бүр хүргүүлэх			акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.	
3.4.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтыг хийж, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах	-	Хяналт шалгалт хийсэн бүртгэлийн тоо	0	30	Тайлант хугацаанд эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хуулийн этгээдийн 59-н бүртгэлд хяналт шалгалт хийхэд УБ-12 маягт бөглөгөөдгүй 5 зөрчил илэрсэнийг зөрчлийн тэмдэглэл бичиж улсын бүртгэгчид танилцуулан зөрчлийг арилган ажилласан.	50%
3.5.	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг бууруулах		Албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн тоо, Эрсдэлийг бууруулсан хувь	0	1	Улсын бүртгэл хөтлөх эрсдлийг бууруулах зорилгоор Шинээр томилогдсон Улсын бүртгэгчид Улсын бүртгэлийн хүний нөөцийн программд байршсан хичээлүүдийг судлан, судласан хичээлтэй холбоотой шалгалтуудыг тухай бүрт өгч авсан үнэлгээ, шалгалтын илтгэх хуудсыг хэлтсийн даргад танилцуулан ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, чиглэлүүдийг тухай бүрт Сумдын улсын бүртгэгч нарт танилцуулан ажиллаж байна. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний дагуу улсын бүртгэгч нарт нотлох баримтын бүрдүүлбэр, холбогдох хууль тогтоомжуудыг бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа зөв ойлгон хэрэглэх талаар онлайн сургалтыг 3, 5 -р саруудад, Хуулийн этгээдийн эрх нээгдсэн 11 бүртгэгчид дадлага ажлын сургалтыг зохион байгуулсан. Бүртгэлд хяналт шалгалт хийж 42 дүгнэлт гарч нийт 6 удаа онлайнаар заавар зөвлөмж өгөөд байна.	50%
3.6.	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллах	-	Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангасан хувь	100%	100%	“Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Хэлтсийн өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд гарсан эвдрэл, гэмтэлийг 56 удаа арилган цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн хэлтсийн албан хаагчдаас ирүүлсэн 23 удаагийн засвар	50%

						үйлчилгээ, програм, бүртгэлийн сүлжээтэй холбоотой дуудлага хүлээн авч, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган сүлжээний асуудлыг 100% хариуцан ажиллаж байна.	
Зорилт 4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
4.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг тооцон ажиллах/5.1/	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Хэлтсийн авлигын эсрэг 2025 оны төлөвлөгөөнд 2 зорилт 6 арга хэмжээг тусган 04 дүгээр сарын 14-нд хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг гарган хүргүүлсэн.	100%
4.2.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, бүртгэх/5.2/	-	Бүртгэгдсэн эцсийн өмчлөгчдийн тоогоор	552	652	Эцсийн өмчлөгчийн бүртгэл хийлгэх хүсэлт ирүүлсэн 267 хуулийн этгээдийн бүртгэлийг хийсэн байна.	50%
4.3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	5	8	Завхан аймгийн прокурорын газартай хамтран Хэлтсийн ажилтан, албан хаагчдад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар”, Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтэстэй хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” зэрэг сургалтуудыг ажилтан, албан хаагчдад зохион байгуулж, Хэлтсийн албан ёсны пэйж хуудсанд байршуулан сурталчилан ажиллаж байна.	100%
Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
5.1.	Байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Дотоод сургалтын төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан 14 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар сумдын улсын бүртгэгч нартай сар бүр улсын бүртгэлтэй холбоотой хуулиудаар 5 удаа, Тоон гарын үсэг олгох сургалтыг 1 удаа, Улсын бүртгэл хөтлөх эрсдлийг бууруулах сургалтыг 1 удаа, Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх сургалтыг 1 удаа, Авилгын эсрэг сургалтыг 2 удаа, Дохионы хэлний дунд хугацааны 16 багц цагийн	100%

						сургалтыг хэлтсийн 9 албан хаагч, Насан туршийн боловсролын төвтэй хамтран Хамт олны уур амьсгал сэдэвт сургалт хэлтсийн хэмжээнд нийт 27 сургалт зохион байгуулж, сургалтад ажилтан, албан хаагчид 100 хувь хамрагдсан байна.	
5.2.	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх, холбогдох хуульд заасны дагуу мэдээллийг цахим хуудаст байршуулах	-	Шинээр томилогдсон улсын бүртгэгч нарын сургалтын системийн хичээлийг судалсан тоо	2	4	2025 оны эхний хагас жилийн байдлаар хэлтсийн нийт албан хаагчид сургалтын нэгдсэн системд шинээр байршуулсан хичээлүүдийг судалж, 80%-аас дээш дүнтэй шалгалтуудыг өгсөн байна. 2025 онд шинээр томилогдсон 1 албан хаагч хүний нөөцийн нэгдсэн системийн хичээлүүдийг судалж байна.	50%
5.3.	Байгууллагын 2025 оны ёс зүйн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг тооцох	-	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган албан хаагчдын дунд ёс зүйн харилцаа хандлагын талаар судалгаа авч, судалгааны дүнг үндэслэн албан хаагчдад “төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар сургалт зохион байгуулан, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэвлэн олшруулж албан хаагчдад танилцуулж “танилцсан” тухай гарын үсэг зуруулан ажилласан. Мөн хүний нөөц сургалтын программд байршуулсан “Ёс зүйн менежментийн дэд бүтцийг бүрдүүлэх арга зам”, “Монгол улсын төрийн албаны үнэт зүйл” хичээлүүдийг албан хаагчид 100% уншиж судалсан.	50%
Зорилт 6.АЗДТГазар болон бусад байгууллагатай хамтын ажиллагааг өрөгжүүлнэ.							
6.1.	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх.	-	Ирүүлсэн хүсэлтийн биелэлтийн хувь	100%	100%	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд улсын бүртгэгчээс 1854, киоск машинаас 2660, хууль хяналтын байгууллагад 233, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн хуулийн	50%

						этгээдэд 85, хууль хяналтын байгууллагад 20, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 100, хууль хяналтын байгууллагад 35 лавлагааг тус тус олгосон. Нийт 4987 лавлагааг иргэн аж ахуй нэгж хууль хяналтын байгууллагад олгон ажилласан.	
6.2.	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	Тайлан хүргэлтийн тоо	12	12	Иргэний улсын бүртгэлийн газарт 5 удаа мэдээ 2 тайлан, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 5 мэдээ, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт 5 удаа мэдээ, 2 тайланг гарган хүргүүлсэн.	50%
6.3.	Улиастай сумын ЗДТГ-тай хамтран Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих.	-	Тарьсан модоо арчлах, услах, нэмж тарих	300ш	400ш	Завхан аймгийн Байгаль орчны газраас “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад мод тарих арга зүйд сургах, дадлагжуулах сургалтад 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хариуцсан албан хаагч сууж, дадлага ажил хийж гүйцэтгэн ажилласан. 2025 оны 05 дугаар сарын 11-ны өдөр бүх нийтээр мод тарих өдрөөр Хэлтсийн хашаанд 10 ширхэг агч мод, “НОГООН УЛИАСТАЙ-ЭКО БАЙГУУЛЛАГА” НОГООН БАЙГУУЛАМЖ ТОХИЖИЛТ” аяны удирдамжийн дагуу Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнгийн гадна хуваарьт газарт 20 ширхэг хайлаас модыг шинээр тарьж, нэмж тарьснаар Хэлтийн ажилтан, албан хаагчид, Сумдын Улсын бүртгэгч нар нийт 355 мод тарьсан дүнтэй байна.	70%
6.4.	Хамтран ажилладаг байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнүүдэд оролцох	-	Арга хэмжээний тоо	4	5	Завхан аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэд сурталчлах өдөрлөг, Хуульчдын “Про боно” өдөрлөг, Отгон, Шилүүстэй суманд нээлттэй хаалганы өдөр, Завхан аймгийн Татварын хэлтсийн албан хаагчидад “Эд хөрөнгийн үнэлгээ” сэдвээр, Аймгийн бизнес эрхлэгчид “Улсын бүртгэлд хуулийн этгээдийг бүртгүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр сургалт, ЗХ-325-р ангиас зохион байгуулсан Тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын спортын арга хэмжээ, БТСГ-н сорил, Нэгдсэн эмнэлэг болон Төрийн тусгай албан хаагчдын	50%

						нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэг, Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран засан хүмүүжигч нарт Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч Тоон гарын үсэг олгох, бүртгэл хийх, Аймгийн засаг даргын тамгын газар Төрийн захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулсан гэх мэт 11 байгууллагатай хамтран 11 арга хэмжээг зохион байгуулсан. Дэлгэрэнгүй тайланг үйл ажиллагааны тайланд оруулав.	
6.5.	Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд нийт албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан тоо	40	44	2025 оны эрүүл мэндийн үзлэгийг Хамгийн чухал нь зорилтот арга хэмжээний хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчийн эмнэлэгийн үзлэгийн багтай хамтран эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх болон эрт илрүүлгийг хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулан 2025 оны 03 дугаар сарын 24-нд 100 хувь хамруулсан. Улмаар 3 ажилтан дараагийн шатны эмнэлэгт нарийн мэргэжлийн оношилгоо хийлгэсэн.	100%
6.6	Иргэний андгай өргөх ёслол зохион байгуулах	-	Арга хэмжээний тоо	1	1	2025 оны 11 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.	50%

---oOo---